



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/1519

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс  
барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 66 дугаар тогтоолын 4.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 24/22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн 74 дүгээр цэцэрлэгийн балансад бүртгэлтэй нийт 512,065,035.00 (таван зуун арван хоёр сая жаран таван мянга гучин тав) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 167,124,645.80 (нэг зуун жаран долоон сая нэг зуун хорин дөрвөн мянга зургаан зуун дөчин таван төгрөг наян мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан цэцэрлэгийн хуучин барилгыг акталж, данс бүртгэлээс хасахыг Чингэлтэй дүүргийн 74 дүгээр цэцэрлэг (С.Оюунчимэг)-т даалгасугай.

2.Акталж, данс бүртгэлээс хасах барилгыг нурааж буулгахад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулахыг Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3.Барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой эд хөрөнгийг худалдан борлуулж 5,431,350.00 (таван сая дөрвөн зуун гучин нэгэн мянга гурван зуун тавь) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Чингэлтэй дүүргийн 74 дүгээр цэцэрлэг (С.Оюунчимэг), орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110206919

Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
... дүгээр сарын ...-ны өдрийн  
... захирамжийн  
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ 74 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Барилга	43	ш	1	487,503,315.00	487,503,315.00	153,096,212.70	334,407,120.30
2	Дулааны шугам	43	м	14	690,480.00	9,666,720.00	4,699,100.00	4,967,620.00
3	Цэвэр бохирын шугам	43	м	100	130,000.00	13,000,000.00	7,583,333.10	5,416,666.90
4	Бохирын турба	43	м	45	38,800.00	1,746,000.00	1,746,000.00	-
5	Мод навчит		ш	20	7,450.00	149,000.00	-	149,000.00
Данснаас хасах хөрөнгийн дүн						512,065,035.00	167,124,645.80	344,940,407.20